



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 11 өдөр

Дугаар

A/35

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, сумын Онцгой комиссын 2021 оны 05 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Сумын нутаг дэвсгэрт спорт заалны үйл ажиллагаа, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, сүм хийдийн хурал цуглаан, үзэсгэлэн худалдаа, кароке, аялал зугаалгын арга хэмжээ зохион байгуулахыг 2021 оны 03 дугаар сарын 11 ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31 ний өдөр хүртэл хугацаанд хориглосугай.

Хоёр: Сум, аймаг, хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг сумын Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлж, суманд нэвтэрч буй иргэд, тээврийн хэрэгслийг бүртгэж ажиллахыг Онцгой комиссын ерөнхий жижүүрүүдэд үүрэг болгосугай.

Гурав: Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтэрч байгаа аютомашин, иргэдэд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлж, иргэдийн PCR шинжилгээнд хяналт тавих шалгалтыг эрчимжүүлж, төв замын постонд ээлжээр жижүүр хийж, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/-т үүрэг болгосугай.

Дөрөв: Голомтын бүс нутгаас эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмчийн 13А маягт, ар гэрийн гачигдлаар ирэх, төрийн ажлаар албан томилолтоор ирж буй сум орон нутгийн иргэдээс бусад иргэдийг хүлээн авахгүй байж дээрх тохиолдлоор ирсэн иргэдийн гэрийн ажиглалтанд байх хугацаанд тавих хяналтыг сайжруулж, мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг багийн Засаг дарга нар, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

Тав: Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэнтэй холбогдуулан төв зам дээр гарах постны хуваарийг 2021 оны 03 дугаар сарын 31 ны өдрийн дуустал өөрчлөн хавсралтаар баталсугай.

Зургаа: Суманд ирж буй хавсралтад дурдсан 11 төрлийн иргэдээс бусад иргэнээс түргэвчилсэн оношлуурын төлбөрийг авч ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /С.Батцэцэг/-т зөвшөөрсүгэй.

Долоо: Тусгаарлалтын байрыг тохижуулж, бэлэн болгон сумын Онцгой комисст хүлээлгэж өгөхийг Эрүүл мэндийн төвийн дарга /С.Батцэцэг/, ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч /Х.Эрдэнэтуяа/ нарт даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ

488010 102

Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11 ны
өдрийн А/35 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Түргэвчилсэн оношлуурын төлбөр төлөхгүй
иргэдийн жагсаалт



1. 16 насанд хүрээгүй хүүхэд
2. Жирэмсэн эмэгтэй
3. Амаржсанаас хойш 56 хоногтой эх
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
5. 60 болон түүнээс дээш настай иргэн
6. Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэн
7. Хорт хавдартай иргэн
8. Тархвар зүйн заалтаар шинжилгээнд хамрагдаж байгаа иргэн, үүнд сэжигтэй тохиолдолд ойрын болон 2 дахь хавьталтай иргэн
9. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай иргэн
10. Зорилтот бүлгийн болон цагдаа, МХГ, ЭМ, ОБГ-ын албан хаагчид
11. Албан үүргээ гүйцэтгэхэд тавигдах шаардлагаар шинжилгээнд хамрагдаж байгаа, үүнд томилолтоор яваа тусгай хамгаалалтанд нэвтрэх төрийн албан хаагч